

**Монгол хэл, аялгуунуудад өгөх болон гарах, чиглэх,
орших тийн ялгалууд салбарлан хөгжсөн нь**

Гэрэлт-Одын БАТЗАЯА*

Монгол Улс, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн

Хэл шинжлэлийн салбарын ЭШАА, доктор (Sc.D), дэд профессор

Хураангуй

Эрдэмтэн судлаачдын тайлбар, судалгаа, орчин цагийн монгол хэл, аялгуунууд дахь нөхцөлүүдийн хэлбэр, утгын хувьсал хөгжлийг өөр хооронд нь харьцуулан судалж, дүгнэлт хийвэл өгөх, орших, гарах, чиглэх тийн ялгалуудын гарал, хувьсал хөгжлийн зам харагдаж байна. Эхлээд орших ба орны утга бүхий үгээс орших ерөнхий утгат бүтээвэр бий болжээ. Энэхүү, монгол хэлний хөгжлийн маш эрт үед үүссэн тийн ялгал нь өнөөг хүртэл өгөх орших тийн ялгал хэмээн нэрлэгдсээр ирсэн бол барагцаагаар эртний монгол хэлний үед хөдлөх утга салбарлан гарсан нь гарах тийн ялгал болжээ. Дараагийн шатанд, дунд үеийн монгол хэлнээс орчин цагийн монгол хэл хүртэлх хөгжлийн явцад газар орон руу чиглэн хөдлөх утгат тийн ялгал үүсэн бүрэлдэжээ. Харин орчин цагийн монгол хэл, аялгуунуудад оршин байх орныг заах нөхцөлүүд бие даасан үгээс шинээр үүсэн бүрэлдэж, өгөх ба орших тийн ялгал салаалан хөгжих хандлага нэгэнт бий болсон байна.

Түлхүүр үгс: өгөх орших тийн ялгал, гарах тийн ялгал, чиглэх тийн ялгал, орших тийн ялгал, монгол төрөл хэлнүүд, аялгуунууд, үг-бүтээвэр

Удиртгал

Мэдэгдэж буй Монголын анхны хэл зүйн бүтээл болох Сажа бандида Гунгаажалцаны “Зүрхэн толт” хэмээх судрыг манай үед уламжилж үлдээсэн, Моломравжамба Данзандагвын XVIII зуунд туурвисан “Зүрхэн толтын тайлбар үсгийн эндүүрлийн харанхуйг арилгагч огторгуйн маани”¹ хэмээх бүтээлд “үйлсийг үзүүлсэн хоёрдугаар, хэргийг үзүүлсэн дөтгөөр, буй орныг үзүүлсэн долдугаар тийн ялгал” хэмээн гурван тусад нь салган нэрлэсэн байдгийг академич Ш.Лувсанвандан “өгөх оршихын тийн ялгал” хэмээн нэрлэсэн (1965:

* © Г.Батзаяа 2024

E-mail: batzaya.g@mas.ac.mn

¹ хойшид “Огторгуйн маани” гэх

25-30)-ээр өнөөдөр сургуулийн хэл зүйд тогтжээ. Данзандагвын нэр томьёоны хувьд, “*qoyaduyar teyin ilyal anu üyiles-i üjegliügsen bölüge. üliigerlebesü dorun-a odoyu, dorun-a odbai kiged örün-e жүг-түр odoyu, oduysan ba tende odoyu, tegün-dür oduysan metü bölüge. yabuqu üyile kiged kürügsen üyile-yi üjegliügsen bolai... dötüger teyin ilyal anu: burqan-dur mörgümüi, yuyilinči-dur idegen ög, bodhi sung-tur takil ergü, ebedčin-e em ög, qamuy amitan-dur tusalaqu-yin tula kiged tariyan-dur usu tataqu ba öglige-yin ejed-tür öljeyitü boltuyai metü bölüge. yağun-u tula dötüger teyin ilyal kemebesü kereg-i üjegliügsen tula bolai... doluduyar teyin ilyal anu burqan-a ayiladqui örüsiyekü bui, burqan-dur nökir bui, dalai-dur čindamani bui, oytaryui-dur naran saran bui, delekei-dür jimis tariyan bui kemekü metü bölüge. yağun-u tula doluduyar teyin ilyal kemebesü bui orun-i üjegliügsen tula bolai*” (Цэрэнсодном, Наранцэцэг, 2021: 73) хэмээснээс үзвэл эхнийх нь “чиглэх”, хоёр дахь нь “өгөх”, сүүлийнх нь “орших” утгатай байна. Ингэж олон салгаж нэрлэсний учир нь монгол хэлний тийн ялгал хэмээх ойлголтыг төвөд хэлний шууд орчуулгаар авч үзсэнтэй холбоотой бөгөөд “...Төвөд хэлнээс монгол руу ном зохиол орчуулахад төвөд хэлний -la, -su, -r, -ru, -du, -tu (-na) нөхцөлийг монгол хэлний дурдсан нөхцөлөөр оноон орчуулдаг уламжлалтай яг тохирдог” (Шагдарсүрэн, 2017: 45) гэж эрдэмтэн Ц. Шагдарсүрэн тайлбарласан байдаг. Харин Өвөр Монголын эрдэмтэн Ц. Пүрэв “...Энэ гурван нэрийдэл болон тус бүрд үзүүлсэн жишээнээс үзэхэд дагавруудын хэлбэр буюу үйлэнд тусч байгаа үгийн утгыг гол болгосон биш харин өгүүлэхүүнээр орж байгаа үйл үгийн утга санааг голчлов уу гэмээр санагдаж байна. Үйлсийг үзүүлсэн жишээнд очих, явах, хүрэх мэтийн ямар нэгэн зүгт хандан чиглэсэн үйлийг, хэргийг үзүүлсэн жишээнд өгөх, мөргөх мэтийн ямар нэгэн тодорхой хэрэг дээр үйлдэж байгаа үйл хөдөлгөөнийг, орныг үзүүлсэн жишээнд буй гэсэн үгээр ямар нэг газарт буюу хүн, юманд оршин тогтнож байгаа утгыг заан үзүүлсэн байна” (Пүрэв, 2019: 416) гэжээ.

Харин гарахын тийн ялгалын нөхцөлийн анхны хэлбэр нь -са/-се байсныг Г.И.Рамстедт (1902), Н.Н.Поппе (1955) нар анх тэмдэглэсэн бол В.Котвич, Чой. Лувсанжав нар тус тус а-са нөхцөл нь орших а болон сау гэдгийн са хоёроос бүтсэн бөгөөд “ахуйгаас улиран хөдлөх” утгатай гэсэн ойролцоо санал дэвшүүлсэн байдаг (Лувсанжав, 1972). “Монголын нууц товчоон”-д өгөх орших, гарахын тийн ялгал давхарлан орсон олон тохиолдлыг эрдэмтэд олж судалсан байна. Тухайлбал, И.Д.Рахевилц “Монголын нууц товчооны индекс” (1972)-дээ даца/деце хэлбэр 66, таца/теце хэлбэр 13 (нийт 79) байгааг тэмдэглэжээ.

Судалгааны арга зүй

Танин мэдэхүй бол бүх шинжлэх ухаан төдийгүй эгэл хүн бүрийн өдөр тутмын амьдралын зүйл. Түүний үндсэн судлагдахуун буюу хүний танин мэдэхүйн арга зам нь мэдэхгүйгээс мэдлэг рүү чиглэсэн дараалалтай байдаг... Хүн олж авсан мэдээллээ ашиглан удаа дараагийн дадлагаар туршлага, чадвар

хуримтлуулан эзэмшдэг. Бодит байдалд оршигч хүн гэдэг амьд биетэд өөрт нь аливаа зүйлийг айчлах арга зам оршин байдаг. Айчлах явцад туршлага бүхий мэдлэг хуримтлагдан, идэвхэжсэн шинжтэй болдог. Ийнхүү өмнөх мэдлэг нь шинэ шинэ мэдлэгийн эх үүсвэр болдог... Айн ойлголт бол хүн төрөлхтөн орчлон ертөнцийн юмс үзэгдлийг хэрхэн хүлээн авч, танин мэдэж, ойлгож ирсэн түүх юм. Энэхүү үйл нь аливаа зүйлийн хил хязгаар, хүрээг тодорхой болгон, хэвшүүлэн тогтоох төрөлхийн үйл явц бөгөөд үүнийг үг хэллэгээр нэрлэн илэрхийлдэг гэх мэтээр танихуйн онол, түүнд суурилсан танихуйн хэл шинжлэлд тайлбарлажээ (Нансалмаа, Долгор, 2014: 22, 168-169, 182-183). Монгол хэлэнд тийн ялгал хэмээх хэл зүйн ай үүсэн бүрэлдсэн, бүтээврүүдийн утга, үүрэг, хэлбэр салаалан хөгжсөн тухай тайлбарлахад энэхүү онол бидэнд чухал удирдамж болов.

Монгол хэлнээс хөгжлийн нь янз бүрийн шатанд тасран салж, бие даан хөгжсөн монгол, дагуур, дуншаан, бао-ань, зүүн ёгур хэлтэн хүмүүс БНХАУ-д, ойрад (халимаг), буриад хэлтэн хүмүүс ОХУ-д амьдарч байна. Афганистан улсад монголын бас нэг угсаатан могол хүмүүс амьдардаг боловч одоо могол хэлээр ярьдаг хүн байхгүй болжээ. Монгол хэлний 4 аялгуу: халх аялгуунаас төв халх аман аялгуу, өвөр монгол аялгуунаас цахар аман аялгуу, ойрад хэл, аялгуунаас дөрвөд аман аялгуу, буриад хэл, аялгуунаас хори-ага буриад аман аялгуу бол тус тус төлөөлөх аялгуу юм. Иймээс гол үүрэгтэй авч үзлээ. Бас бидний судалгаанд хувь нэмэр болохуйц өвөрмөц сонирхолтой жишээ баримт бусад аман аялгуунд байгааг авч орууллаа.

Бид энэхүү өгүүлэлдээ бүтэц судлалын арга болоод харьцуулан судлах аргыг голлон баримтлав. Мөн ажиглалт, туршилт, индукц, дедукц, анализ, синтезийн арга гэх мэт шинжлэх ухааны ерөнхий аргууд болон товчоолох, сан бүрдүүлэх зэрэг хэл шинжлэлийн тодорхой аргазүйг ашиглав. Сан бүрдүүлэхдээ: нэгдүгээрт тухайн хэл, аялгуугаар ярьдаг хүмүүсийн аман ярианаас, хоёрдугаарт тухайн хэлний журамласан хэл зүйн бүтээлүүдээс, гуравдугаарт монгол төрөл хэлнүүдийн хэвлэмэл дата материалаас авав. Тухайлбал: 1. Миний бие хэл шинжлэлчийн мэргэжил эзэмшсэнээсээ хойш 30 жил (жил бүр 1-2 удаа 7-20 хоног) нутгийн аялгуу судлах экспедицээр Монгол, Орос, Хятад улсын хот, хөдөөгөөр явж, монгол, ойрад, буриад хэлтэн 1000 гаруй хүнтэй уулзан ярилцаж баримт хэрэглэгдэхүүн цуглуулсан билээ. Ихэвчлэн энгийн ярилцаж байхдаа янз бүрийн хэмжээний аудио бичлэг хийж, түүн дотроос тухайн үед өөрийн судалж буй сэдэвтэй холбоотой үг, өгүүлбэрийг тэмдэглэж, галиг үсгээр бичиж авах аргаар ажилласан. 2. МУБИС-аас хэвлүүлсэн “Орчин цагийн монгол хэл” (Улаанбаатар, 2010), ӨМИС-аас хэвлүүлсэн “Одоо үеийн монгол хэл” (Хөххот, 2005), Ю.Цэндээ “Ойрад аялгууны хэл зүй” (Улаанбаатар, 2012), Д.Д.Доржиев “Өнөөгийн буриад хэл” (Улаан-Үд, 2002) зэрэг ном нь монгол хэлний халх, өвөр монгол, ойрад ба буриад хэл, аялгууны тухай гол баримжаа бүтээлүүд юм. 3. Мөн Энхбат нарын “Дагуур хэлний үг хэллэгийн материал” (Хөххот, 1985), Бөх нарын “Дуншаан хэлний үг хэллэгийн материал” (Хөххот, 1987), Чен Най Шиүн нарын

“Бао-ань хэлний үг хэллэгийн материал” (Хөххот, 1987), Булчулуу нарын “Зүүн Ёгур хэлний үг хэллэгийн материал” (Хөххот, 1987), Чингэлтэй нарын “Монгол хэлний үг хэллэгийн материал” (Хөххот, 1988) номуудаас жишээ баримт авч ашиглав. Жишээ баримтыг бичихдээ аман ярианаас авсан жишээг IPA (International Phonetic Alphabet) олон улсын галигаар тэмдэглэв. Харин монгол, өвөр монгол, халимаг, буриад хэл, аялгууны уран зохиолоос авсан өгүүлбэрүүдийг тухай тухайн хэлний бичгээр бичиж, дор нь дуудлагаар нь галиглав. Бичгийн эх сурвалжаас авсан баримтыг бол бичгийн галигаар бичлээ.

Судалгааны үр дүн

1. Өгөх тийн ялгал

Дээр дурдсанчлан, монгол хэлний эртний, үндсэн тийн ялгал болох өгөх оршихын тийн ялгал орчин цагийн монгол хэлнүүдэд үндсэн утгаараа байсаар байна. Халх аялгуунд [-t/-tʰ] нөхцөл ба түүний (0) хувилбартай. Жишээ нь (1.1a):

(1.1a) *Дулмаа мөнгөн аяганд бялхамархихийж Эрдэнэд ^{өгөх т.я.} барихад Эрдэнэ шазуураа зууж хүйтэн инээмсэглэн толгойгоо сэгсрэв. (Ч.Лодойдамба).*

[tulma: mɔŋkɛŋ ajkɛnt pʲalχəm ærɛx xi:ʃ ertɛnt pærχət ertɛn ʃatsʊ:ra: tsu:ʃ xuiʰɛŋ ine:msɛʊlɛn tʰɔlkɛ:ko: sexsrɛw]

Өгүүлбэрийн зэрэгцсэн гишүүдийн эцсийн бус гишүүдэд (0) хувилбар илэрнэ. Жишээ нь (1.1б):

(1.1б) *Эцэг(0) ^{өгөх т.я.}, эх(0) ^{өгөх т.я.}, үр хүүхдэд ^{өгөх т.я.}-ээ хайртай.*

[ɛtsʰɛk ɛx ur xu:xɔtte: χæ:rtʰæ:]

Мөн албан бичгийн найруулгад хүндэтгэлийн утга заах зэрэг цөөн тохиолдолд [-a:/-e:/-ɔ:/-ø:] нөхцөл хэрэглэдэг. Жишээ нь (1.1в):

(1.1в) *Ерөнхий захирал танаа ^{өгөх т.я.}*

[jɛrɛŋxi: tsæxrɛl tʰana:]

Өвөр монголд бас [-t/-tʰ], [-a:/-e:/-ɔ:/-ø:] нөхцөлтэй. Жишээ нь (1.2a,б):

(1.2a) [yɛnt ^{өгөх т.я.} ɔrɛχ, tsʰɛrɛxtʰ ^{өгөх т.я.} mɔrtɛχ, ɔwɛʏt ^{өгөх т.я.}-øŋ χæ:rtʰæ:]

(1.2б) [ʃæxrɛl θana: ^{өгөх т.я.}] гэх мэт.

Хорчин, харчин түмэд аман аялгууны зарим нутагт [-tʰɛ:] нөхцөл байна. Жишээ нь (1.2в):

(1.2в) [paxʃnɛ:tʰɛ: ^{өгөх т.я.} ɔk], [mɛnɛ:tʰɛ: ^{өгөх т.я.} irʃ].

‘багшид нь өг’, ‘манайд иржээ’

Монгол хэлний халх аялгуунд байрлуугаа явах, хотруу явах, гэрлүүгээ харих гэх мэтээр их төлөв чиглэх тийн ялгалаар илэрхийлдэг утгыг өвөр аялгуунд [pɛ:rta:n jawɛχ] ‘байрдаа явах’, [χɔtʰɛt jawɛχ] ‘хотод явах’, [kɛrtʰɛ:n χɛrɛχ] ‘гэртээ харих’ гэх мэтээр ихэвчлэн өгөх орших тийн ялгалаар илэрхийлж, хааяа зарим аман аялгуунд чиглэх тийн ялгалыг хэрэглэдэг.

Буриад хэлний хэл зүйд “зүгэй падеж” гэж дан утгаар нь нэрлэх (Доржиев,

² т.я - тийн ялгал

2002) боловч бусад монгол хэл, аялгуутай адил утга илэрхийлэх [-da/-de/-dɔ], [-tʰa/-tʰe/-tʰɔ] гэсэн нөхцөлтэй. Жишээ нь (1.3):

(1.3) Харин тийхэдэ^{өгөх т.я.} би хургуулид^{өгөх т.я.}-аа хурахад^{өгөх т.я.}-аа наадажа үнгэрэхынгөө хажуугаар заримдаа гэрэйнгээ даабари дүүргэнгүй, багшынгаа нүдэннөө бээе далдалан үнгэргэдэг байгаа. /Б-Р.Батажабай/³

[χærin tʰi:xede bi hɔrɣu:lida: hɔrɣada na:daʒa ʊŋgergexi:ŋgø: χaʒʊ:ka:r zarimda: gereiŋge: da:bari du:ɣeŋɣui baʃʃi:ŋga: nʲudeŋhø: beje: daldalaŋ ʊŋgerɣedeg bæ:ka:b]

‘Харин тэгэхэд би сургуульдаа сурахдаа наадаж өнгөргөхийнхөө хажуугаар заримдаа гэрийнхээ даалгавар дүүргэлгүй, багшийнхаа нүднээс биеэ далдан өнгөргөдөг байлаа.’

Ойрад аялгуунд [-t/-tʰ] нөхцөлтэй бөгөөд мөн л бусад монгол хэл, аялгуунаас онцын ялгаагүй. Жишээ нь (1.4а,б):

(1.4а) [pa:tʰər kʰymn nik sʊmɐnt^{өгөх т.я.}, paɣna: maɪ nik tsʊ:χt^{өгөх т.я.}]

‘Баатар хүн нэг суманд, баяны мал нэг шуурганд’

(1.4б) [kʰymnæ: qatsər(0)^{өгөх т.я.} neræ:n, ewræ:ŋ qatsər(0)^{өгөх т.я.} jasa:n]

‘Хүний газар нэрээ, өөрийн газар ясаа.’

Халимагийн ойрад хэлэнд [-ti/-te], [-tʰi/-tʰe] нөхцөлтэй. Жишээ нь (1.4в):

(1.4в) агды^{өгөх т.я.}, гэрелде^{өгөх т.я.}, хавырты^{өгөх т.я.}, төмерте^{өгөх т.я.(4)}

[aɣtʰi, [kerelte], [χawɪrtʰi], [tʰømertʰe]

‘тосонд, гэрэлд, хаварт, төмөрт’

Халимаг хэлэнд хааяа -dur/-tur, -du/-tu нөхцөл тохиолддог гэж Го.Зоригт нар тэмдэглэсэн байна (Зоригт, 2001: 72-76). Гэвч халимаг хэлний журамласан хэл зүйд байхгүй байна.

Дагуур хэлэнд [-t/-tʰ] нөхцөл байна. Жишээ нь (1.5а):

(1.5а) [ʃin ʊʃɣut^{өгөх т.я.} pi ʒɔ:kʰə: nastʰi: pi. -pi ʊʃɣut^{өгөх т.я.} ʃi: tʰæptʰi: ʃi]

‘Чиний үзэхэд, би хэдэн настай би? - Би үзэхэд чи тавьтай чи.’

Мөн [-ə] нөхцөл байх бөгөөд тус нөхцөлөөр хамтрах утгыг илтгэдэг тохиолдол бий. Жишээ нь (1.5б):

(1.5б) [χa:nnə^{өгөх т.я.} aʊʃʃi:sən]

‘хаантай уулзсан’ гэх мэт.

Монгол хэлэнд [-te/-tu] нөхцөлтэй. Жишээ нь (1.6):

(1.6) [tʰe qœlɔte^{өгөх т.я.} mʊyɪʊ sarare pɔli:ŋke ireʃʃa]

‘Тэр хоёуланд өмнөх сард хүүхэд иржээ.’

Энэ нөхцөлөөр үйлдэх, гарах утгыг илтгэх тохиолдол бий. Жишээ нь: [tɕi fʊʊʊarne dʒamte alaga] - ‘Чи үхрээ тогоочоор алуул’. [kʰurɣe:nte sga] - ‘Хүргэнээс асуу’ гэх мэт.

³ Буриадын бичгийн хэлээр

⁴ Халимагийн бичгийн хэлээр

Дуншаан хэлэнд [-tə] нөхцөл байна. Жишээ нь (1.7a):

(1.7a) [tʃimatə^{өгөх т.я.} tʃajə waino]

‘Чамд цай байна уу?’

Мөн [-ə] нөхцөл байна. Жишээ нь (1.7б):

(1.7б) [irəsənə]^{өгөх т.я.}

‘ирсэнд’. Тус нөхцөлөөр заах, гарах, үйлдэх утгыг илтгэдэг. Жишээ нь:

[sonʃotə tʃuandzidzi tawanə] - ‘Нарс модыг нэвтэлж чадна’. [ʃitsitə asaʃʊə] - ‘Арслангаас асуужээ’. [matə kiəgasə ɔlonə] - ‘Надаар хийлгэж болно’ гэх мэт.

Бао-ань хэлэнд [-tə/-tʰə] нөхцөл байна. Жишээ (1.8):

(1.8) [ɔdzan kʰantə^{өгөх т.я.} ətwa:]

‘Тэр хэнд одов?’

Бао-ань хэлний тус нөхцөлөөр бас заах, гарах, үйлдэх утгыг илтгэх тохиолдол байна. Жишээ нь: [təə monə niortə dza] - ‘Чи миний нүүрийг үз’. [teintə garʃənə] - ‘чамаас гарна (сална)’. [ənə ɔnaŋnə tʃʊtsitə dzarga] - ‘Энэ үнээг тогоочоор алуул’. [khɔŋla mɔrtʰə thɔrtɛi jɔrtɛi jawɔdzə] - ‘Хүмүүс замаар нааш цааш явна.’ гэх мэт.

Зүүн ёгур хэлэнд [-tə/-tʰə] нөхцөлтэй. Жишээ нь (1.9):

(1.9) [tʰərə ʃɔʏtʰə^{өгөх т.я.} htei mɛla paimo:]

‘Тэр цугт бага хүүхэд байна уу?’

Зүүн ёгур хэлний тус нөхцөлөөр хамтрах, заах (шууд тусагдахуун), гарах, үйлдэх тийн ялгалын зарим утгыг, мөн нэрлэхийн тийн ялгалын утга буюу өгүүлэгдэхүүнийг илэрхийлдэг. Жишээ нь: [pʊ ʃəmatə maltʰalʃʰaja] - ‘Би чамтай малталцъя’. [tʰə monə zagalatə ɣalta] - ‘Чи миний хөргийг үз’. [ʃa:pətə sɔra] - ‘Ламаас сур’. [kʰy:s mɔrtʰə naɣʃə rəʏə: ʃhayaʃə jarɣa:] - ‘Хүмүүс замаар нааш цааш явна’. [monə nɛrətə tʰɔja kətək pei] - ‘Миний нэр Туяа гэдэг’.

Уг тийн ялгал нь орчин цагийн монгол хэлнүүдэд өгүүлбэрийн дотор шууд бус тусагдахуун, эсвэл байц гишүүнээс үйлд харьцах харьцааг зааж, утгын хувьд: өгөх болон орших үндсэн утга илэрхийлдгээс орших утга нь шинээр үүсэн бүрэлдэж буй нөхцөл бүхий бие даасан тийн ялгал болон салаалж байгаа тухай доор авч үзнэ. Мөн чиглэх утга илэрхийлэх нь улам бүр цөөрч, шинээр үүссэн чиглэх тийн ялгалд шилжиж байна. Өгүүлбэрийн хам бүтцэд бас багтах, харьяалагдах (шуурганд туугдах, уйтгар гунигт автах), өртөх (надад хэлсэн), тэнцэх (үнэгэнд хувилах, аавын оронд аав болох), хамтрах (адуунд ижилсэх), цаг (өдөрт нь дуусгах, жилээс жилд сайжрах), шалтгаан (халуунд нозоорох, өвчиндөө ядрах), зорилго (авд мордох, сургуульд сурах), чиглэл (ажилдаа явах, гэртээ харих) гэх мэт утга илэрхийлнэ.

Харин дундад зууны монгол хэлэнд эдгээрээс гадна: хэр хэмжээ (*qabirqa-ta*

qa'ulqa ebüdüg-te ölkek boltala debsebe), хамтран ба харилцан үйлдэх эзэн (*aqa de'ü-tür sayi ijilidülçen бүкүй*), салах гарах орон (*irgen-tür ...sura'asu*), шууд тусагдахуун (*ireküy-e üjeksen*), харьяа хамаа (*yekes-e qajaru*), багаж хэрэгсэл (*tebene-de qatququy*)-ийн утга заадаг байсан нь одоо бусад тийн ялгалд шилжжээ (Зоригт, Элсэнцэцэг, 2001: 53-66). Гэхдээ төрөл монгол хэлнүүдэд, мөн монгол хэлний зарим аялгуунд дундад зуунд илэрхийлж байсан утгаа одоо ч хэвээр хадгалж буй үзэгдэл цөөн биш байгааг дээр тэмдэглэв. Тухайлбал: хамтран үйлдэх эзний утгыг зүүн ёгур, дагуур хэлэнд; шууд тусагдахууны утгыг зүүн ёгур, дуншаан, бао-ань, монгол хэлэнд; салах, гарах утгыг зүүн ёгур, дуншаан, бао-ань хэлэнд; багаж хэрэгслийн утгыг монгол, дуншаан, бао-ань хэлэнд илэрхийлж байна. Мөн чиглэх утгыг монгол хэлний өвөр аялгуунд заасаар байна.

2. Гарах тийн ялгал

“Огторгуйн маани”-д “гарах угийг үзүүлсэн тавдугаар тийн ялгал” хэмээн нэрлэсэн нь эдүгээ “гарах тийн ялгал” нэрээрээ хэвшжээ. Орчин цагийн монголын утга зохиолын хэлний суурь халх аялгуунд [-a:s/-e:s/-o:s/-ö:s] нөхцөл ба түүний (0) хувилбараар илэрнэ. Жишээ нь (2.1а,б):

(2.1а) *Тэгээд эхнэрийнхээ гараас*^{гарах т.я.} *хөтөлж, гэрээс*^{гарах т.я.} *гараад шууд их гэрийн зүг алхав. (Ч.Лодойдамба).*

[tʰeʏe:t exnəri:ŋxe: qara:s xətʰəlʃ kere:s qara:t ʃu:t ix keri:n tsuk alʃəw]

(2.1б) *Энд(0)*^{гарах т.я.}, *тэндээс*^{гарах т.я.} *цугларсан олон хүн*

[ent tʰente:s tʰuʃərsəŋ oləŋ xun]

Өвөр аялгуунд [-a:s/-ə:s/-o:s/-ö:s] нөхцөлтэй, хорчин аман аялгуунд [ə] эгшиг байхгүй тул гурван хувилбартай. Жишээ нь (2.2):

(2.2) [paʃa:s^{гарах т.я.} surəlʃʰ, ʃʰe:ka:s^{гарах т.я.} ʊ:, ʃʰasna:s^{гарах т.я.} ʃʰaka:ŋ]

‘багшаас суралц, цайнаас уу, цаснаас цагаан’

Буриадад мөн “гаралай падеж” гэж нэрлэх (Доржиев, 2002) бөгөөд [-ha:/-he:/-hə:/-hə:] нөхцөлтэй. Жишээ нь (2.3):

(2.3) *Баашиха үбгэн хуурмагша юумэ дархалха ой ухаанһаа*^{гарах т.я.} *дурагуй, шадаал һаа мүнхэ байха юумэ бүтээхэ гэжэ үнэн зүрхэнһөө*^{гарах т.я.} *хүсэдэг байгаа. (Х.Намсараев).*

[ba:ʃxa ubʏeŋ xu:rmaʃa jume darʃalxa œ: uxa:ŋha: doraʏui, ʃata:l ha: muŋxe pæ:xa jume butʰe:xe geʒe uneŋ zurxeŋhə: xusedeg bæ:ka:]

‘Баашиха өвгөн хуурмаг юм дархлах ой ухаанаас дургүй, чадаа л бол мөнх байх юм бүтээх гэж үнэн зүрхнээс хүсдэг байв.’

Ойрад хэл, аялгуунд [-a:s/-æ:s] гэсэн эр, эмээрээ эсрэгцсэн хоёр хувилбарт нөхцөлтэй. Жишээ нь (2.4а,б):

(2.4а) [amna:s^{гарах т.я.} qaʃ qarən altəx, nykʰnæ:s^{гарах т.я.} poltʰæ:χ]

‘амнаас гал гаран алдах, нүхнээс бултайх’

(2.4б) [χotʰχa: tselkʰæ:(0)^{гарах т.я.}, χotʰ mʊ:ka:s^{гарах т.я.} seryəmʃiʃ]

‘Хулгай зэлгий, худал муугаас сэрэмжил’.

Халимагийн ойрад хэлэнд дунд үеийн монгол хэлний ЭГЭ бүтцийг уламжилсан [-a:si/-e:se] хэмээх нөхцөл байна. Жишээ нь (2.4в):

(2.4в) [χothna:si^{гарах т.я.}, gere:se^{гарах т.я.}]

‘хотноос, гэрээс’ гэх мэт.

Дагуур хэлэнд гарах тийн ялгалын [-a:s/-ə:s/-ɔ:s/-e:s] болон [-a:r/-ə:r/-ɔ:r/-e:r] хоёр нөхцөлтэй, энэ хоёр нь адил утгатай. Жишээ нь (2.5):

(2.5) [təy:je:s^{гарах т.я.} min χasɔ: ~ təy:je:r^{гарах т.я.} min χasɔ:]

‘Дүүгээс минь асуу’.

Монгол хэлэнд [-sa] нөхцөлтэй. Жишээ нь (2.6):

(2.6) [mərɪsa^{гарах т.я.}, kʰɔnsa^{гарах т.я.}, ʃɪresa^{гарах т.я.}]

‘мориноос, хүнээс, ширээнээс’ гэх мэт.

Дуншаан хэлэнд [-sə] нөхцөл байна. Жишээ нь (2.7):

(2.7) [pi makasə^{гарах т.я.} qɔŋtsɔ kienə]

‘Би маргаашаас ажил хийнэ’.

Дуншаан хэлэнд тус нөхцөлөөр үйлдэх утгыг илтгэх тохиолдол байна. Жишээ нь: [talɔ mɔsə ɔtsʊnə] - *‘их замаар очно’* гэх мэт.

Бао-ань хэлэнд бас [-sa] нөхцөл байна. Жишээ нь (2.8):

(2.8) [ensa^{гарах т.я.} tawu xɔlɔ wa]

‘Энэнээс бүр хол байна’.

Бао-ань хэлэнд тус нөхцөлөөр үйлдэх утгыг илтгэх тохиолдол байна. Жишээ нь: [teinə nɔrɛsə ʊrɛsən] - *‘чиний нэрээр дуудсан’* гэх мэт.

Зүүн ёгур хэлэнд [-sa/-se/-so/-si] нөхцөлтэй. Жишээ нь (2.9):

(2.9) [entese^{гарах т.я.} jimar ʃiŋɣe xɔlɔ pa:n]

‘Эндээс ямар зэрэг хол байна?’

Зүүн ёгур хэлэнд тус нөхцөлөөр үйлдэх утгыг илтгэх тохиолдол байна. Жишээ нь: [tʰynse maltʰa] - *‘түүгээр малт’* гэх мэт.

Гарах тийн ялгал нь орчин цагийн монгол хэлнүүдэд аливаа үйлийн эхлэх цэгийг цаг хугацаа (*үүр цайхаас эхлээд*), орон зайн (*хөдөөнөөс хот руу*) харьцаанд үзүүлдэг хоёр гол утга заана. Мөн бүхлийн хэсэг (*хоолноос идэх*), харьцуулан онцлох (*цаснаас цагаан*), шалтгаан нөхцөл (*нойрноос морио*), салан холдох (*зовлонгоос ангижрах*), бүтэх эвлэх (*хүнээс дэм авах*), онцлон ялгах (*олноос онцгой*), эзэн бие (*хурлаас шийдвэрлэх*) гэх мэт 15 хүртэлх төрлийн утга илтгэдэг болохыг эрдэмтэд тэмдэглэжээ (Барайшир, 2012: 144-161). Дундад зууны үед

эдгээрээс гадна багаж хэрэгсэл, тусагдахууны утга илэрхийлдэг байсан нь одоо үгүй болжээ (Зоригт, 2001: 84-86). Гэхдээ багаж хэрэгслийн утга нь орчин цагийн монгол хэлэнд байхгүй ч дуншаан, зүүн ёгур, бао-ань хэлнүүдэд байгааг дээр дурдав.

3. Чиглэх тийн ялгал

Монгол хэлний сургуулийн хэл зүйд 1990-ээд он хүртэл тийн ялгал хэмээн тооцогдоогүй байсан бөгөөд “уруу”, “өөд” хэмээх бие даасан үгээс үүдэлтэй. А.Лувсандэндэв 1954 онд бичсэн “Наймдугаар үндсэн тийн ялгал” өгүүлэлдээ “Уруу бол монгол хэлний үг нь өөрийнхөө хэлний зүйн хөгжилд биеэ даасан үгээс дагавар үг зэргийг дамждаг гэсэн эрдэмтдийн үгийг батлах бас нэгэн баримт... бөгөөд аажуудаа хэзээ нэгэн цагт авианы бүрэлдэхүүнд өөрчлөлт орох нь зүй тогтоолтой хэрэг” хэмээн бичиж, “зүг чиг заах тийн ялгал” хэмээн нэрлэжээ (Лувсандэндэв, 2017: 136-140). Түүнээс хойш Ш.Лувсанвандан “чиглэх тийн ялгал” хэмээн нэрлэснээр өнөөгийн монгол хэлний хэл зүйд хэвшиж, сургуулийн хэл зүйд үндсэн тийн ялгалын бүрэлдэхүүнд оржээ (“Монгол хэл - 6”, 2018).

Орчин цагийн монгол хэлний халх аялгуунд [-ru:/-ru:/-lu:/-lu:], [-a:t/-e:t/-ɔ:t/-ø:t] хэмээх үндсэн хоёр нөхцөл, түүний (0) хувилбараар илэрнэ. Жишээ нь (3.1a,б):

(3.1a) Дулмаа хэлснээр нь яваад ир гэдэг дохио хулгайн нүдээр ламд өгөөд шууд майханруу^{чиглэх т.я.} явлаа. (Ч.Лодойдамба).

[tɔlma: xɛlsne:rən jawɑ:t ir ketək tœxɔ: xɔlʁæ:n nute:r lɑmt ɔyø:t fʊ:t mæ:xəŋru: jawla:]

(3.1б) Гэрээд^{чиглэх т.я.} -ээ явна.

[kɛre:te: jawən]

(3.1в) Нутаг ус(0)^{чиглэх т.я.}, гэр оронлуу^{чиглэх т.я.} -гаа яарах

[nʊtʰək ʊs(0) kɛr ɔrənʊ:ʁɑ: ja:rəx]

Мөн аман ярианд [tɛlyu:r jawəx] - ‘дэлгүүр явах’, [xɔtø: qarəx] - ‘хөдөө гарах’, [surkʏ:ɪ ɔrəx] - ‘сургууль орох’ гэх мэтээр ярих бөгөөд энд буй нэр үгс чиглэх тийн ялгалд байгаа нь үйл үгийн утгаас ойлгогдоно. Жич: 2018 онд шинэчлэн хэвлэсэн кирилл бичгийн “Зөв бичих дүрмийн журамласан толь”-д уг тийн ялгалын нөхцөлийг өмнөх үгээс нь салангид бичихээр тусгасан нь зарчмын хувьд буруу юм. Нэгэнт монгол хэлний үндсэн тийн ялгалын бүрэлдэхүүнд оруулсан тул бусад тийн ялгалын нөхцөлийн адил өмнөх үгтэй нь залгаж, улмаар “зөөлний тэмдэг и болох” зэрэг аливаа дүрэмд захируулан бичих нь зүйтэй. Жишээ нь: гэрээдээ, уулаад, манайхруу, гэрлүү, сургуулируу⁵ гэх мэт.

Ойрад хэл, аялгуунд [-ɔ:t/-y:r] хэмээх нөхцөлтэй. Мөн торгуудын салбар аман аялгуунд [-a:t/-æ:t] нөхцөл, өөлд, мянгад аман аялгуунд [-ʊ:/-ɪ:] нөхцөл байна. Жишээ нь (3.2a,б,в):

⁵ Зөөлөрсөн эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд эгшигт гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад зөөлний тэмдэг хувирдаг. барь-барилаа, боль-болино гэх мэт.

(3.2a) [nyty:r^{ЧИГЛЭХ Т.Я.}-n ts^hɔ: χæɫæ:w]

‘Нүдрүү нь цоо ширтэв’.

(3.2б) [ɔ:lɑ:t^{ЧИГЛЭХ Т.Я.} ɔtnāw]

‘Уулаад одно би’

(3.2в) [æ:lɔ:t æ:mæk(0)^{ЧИГЛЭХ Т.Я.} χɔt^h(0)^{ЧИГЛЭХ Т.Я.} ik^h ny:ʃæ:næ:]

‘Айлууд аймаг, хот их нүүж байна’.

Ойрад хэл, аялгууны чиглэхийн тийн ялгалтай холбоотой тэмдэглэх нэг зүйл бол: [χɔ:r] - ‘хойш’, [χɔ:ra:n] - ‘хойшоо’, [ømæ:r] - ‘өмнөш/урагш/’, [ømæ:ræ:n] - ‘өмнөшөө /урагшаа/’ хэмээх хөдлөх зүг чиг заасан орон цагийн нэрс юм. Бусад аялгуунд [-ʃ/-χ] - ‘-ш/-гш’ дагавартай (жишээ нь халхад хой+ш, хой+ш+оо, ур+гш, ур+гш+аа, өвөр аялгуунд хой+ш, хой+ш+оо, өмнө+ш, өмнө+ш+өө) байдаг бол ойрадад [χɔ:-]<qoi, [øm-]<emü- язгуурт залгасан чиглэхийн тийн ялгал нь өмнөх язгууртайгаа нягт холбогдож, орон цагийн нэрийн үндэс үүсгэсэн байна. Халх аялгуунд уг тийн ялгалын нөхцөл бие даасан үгээс үүссэн бол ойрад хэл, аялгуунд чиглэх утгыг илэрхийлж байсан бүр эртний -ru>-г бүтээвэр хадгалагдан үлджээ.

Буриад хэл, аялгуунд чиглэх тийн ялгал гэж байхгүй, [horxɔ:lida ɔʃχɔ] - ‘сургуульд очих’, [χadanda jawχa] - ‘уулруу явах’ гэх мэтээр ярьдаг. Өрөөр хэлбэл халх шиг чиглэх тийн ялгал үүсэн бүрэлдэж, өгөх орших тийн ялгалаас үйлийн чиглэл заах үүргийг таслан аваагүй байна.

Өвөр монголын цахар, ордос аман аялгуунуудад [-ru:/-ru:/-lu:/-lu:] нөхцөлтэй. Гэвч энэ нь халх аялгууг бодвол бичгийн хэлэндээ нэвтрээгүй, одоо ч (uɣuɣu) хэмээн бичиж буй тул өвөр монгол эрдэмтэд “үндсэн бус тийн ялгал”, “ярианы хэлний тийн ялгал” (Чингэлтэй, Чойжинжав, 2005: 400) гэх мэтээр нэрлэж байна. Алшаа эзнээ аман аялгуунд [-a:t/-æ:t] нөхцөлтэй. Өвөр Монголын зүүн аман аялгуунуудад энэ утгыг чиглэх тийн ялгалаас илүү [əmləxt^h jəwi:] - ‘эмнэлэгт явъя’, [pɛ:rtɑ:n jəwi:] - ‘байртаа явъя’ гэх мэтээр өгөх оршихын тийн ялгалаар илэрхийлдэг нь буриад хэл, аялгуутай адил юм. Халхад ч бас [sɔrkɣ:lt jawəχ] - ‘сургуульд явах’, [kɛrt^hɛ: χæɣəχ] - ‘гэртээ харих’ гэх мэтээр ярьдаг боловч ингэж өгөх оршихын тийн ялгалаар зүг чиг заах тохиолдол бараг энэ хоёр үгээс өөр байхгүй болж, чиглэхийн тийн ялгал идэвхтэй хэрэглэгдэж байна. Үүнээс гадна үзэмчний салбар аман аялгуунд [ʃuk] - ‘зүг’ хэмээх үгээс гаралтай [-ʃu:/-ʃu:] гэсэн нөхцөл бий. Жишээ нь (3.3):

(3.3) [kɛrtʃu:^{ЧИГЛЭХ Т.Я.} χɛɣəχ], [sɔrkɣ:ltʃu:^{ЧИГЛЭХ Т.Я.} irəχ]

‘гэр лүү харих’, ‘сургууль руу ирэх’ гэх мэт.

Монгол хэлэнд бас иймэрхүү [-dzə]⁶ нөхцөл бий. Жишээ нь (3.4):

(3.4) [nta:dzə^{ЧИГЛЭХ Т.Я.} ire]

⁶ Өвөр монголын аялгуунуудад хятад хэлнээс орж ирсэн [dz], [dz], [tɕ], [ɕ] зэрэг гийгүүлэгчийг судлаачид “хэл матийх гийгүүлэгч” гэж нэрлээд, “Авиалахад хэлний үзүүр дээш матирч, хатуу тагнайн өмнө хэсэгтэй хамжин нийлээд /ойртон шүргээд...” гэж тайлбарласан байдаг (Гарьд нар, 2007: 90-91)

‘Надруу ир’ гэх мэт.

Дуншаан хэлэнд [-run/-lon] нөхцөлт зүглэлийн тийн ялгал байдаг (Насанбаяр, 1961: 53-107). Жишээ нь (3.5):

(3.5) [nama:lon^{ЧИГЛЭХ Т.Я.} ire]

‘Надруу ир’ гэх мэт.

Зүүн ёгур хэлэнд мөн энэхүү тийн ялгал идэвхтэй хэрэглээтэй. Гэхдээ нөхцөл нь монгол хэлнээс ялгаатай [-pi:t], [-i:t], [-u:t/-u:r] хэмээх гурван хэлбэртэй бөгөөд [-pi:t] нь бүдүүвч чиглэл, [-i:t] нь өөдлөх чиглэл, [-u:t/-u:r] нь уруудах чиглэлийг заадаг ажээ. [-pi:t] нь bi (бие)+dә>[pite] (ойр орчин) хэмээх бие даасан үгээс үүсэлтэй. Жишээ нь (3.6):

(3.6) [tʰeme:n qusunpi:t^{ЧИГЛЭХ Т.Я.} japʃila neye hyur tʃəna tʰuɣlaʃʃɔɣʃai]

‘Тэмээ усруу явж байгаад нэг сүрэг чононд учирчээ’.

Энэ тийн ялгал утгын хувьд аливаа үйлийн чиглэл заах гол утгатайгаас гаднаас өртөгч (*гар луу цохих*), дотроосоо өртөн үйлдэх (*толгой руу хамгах*) утга илэрхийлнэ.

4. Орших тийн ялгал

Өвөр монгол эрдэмтэд цахар, баарин аман аялгуунд байдаг, [tɔtʰər] - ‘дотор’ хэмээх үгээс үүдэлтэй [-tʰər] нөхцөл, буриад хэл, аялгууны [dɔsɔ:] - ‘дотор’ хэмээх үг, [sɔ:] - ‘цоо’ хэмээх язгуураас үүдэлтэй [-sɔ:] нөхцөл, мөн түүнчлэн дагуур хэлэнд байдаг [-a:tʰən/-ə:tʰən/-ɔ:tʰən/-e:tʰən] нөхцөлийг “дотор орших тийн ялгал” хэмээн нэрлэсэн байна (Чингэлтэй, Чойжинжав, 2005: 396). Мөн цахар, ордос аман аялгуунд байдаг deger-e>[te:r] хэмээх үгээс үүссэн [-ta:r/-tə:r/-tɔ:r/-tə:r] нөхцөлийг “орон байрын тийн ялгал” хэмээн нэрлэжээ (Чингэлтэй, Чойжинжав, 2005: 397). Харин бид, эдгээр нь ижил утгатай бөгөөд “орших тийн ялгал” хэмээн нэрлэх нь зүйтэй гэж үзэв. Жишээ нь (4.1):

(4.1) баарин. [muntʰər^{ОРШИХ Т.Я.} xi:sən]

‘Мөн энэ дотор хийсэн’.

(4.2) буриад. [ɢɔlsɔ:^{ОРШИХ Т.Я.} zakahaŋ ɔlɔŋ]

‘Гол дотор загас олон’.

(4.3) дагуур. [kərə:tʰən^{ОРШИХ Т.Я.}]

‘гэр дотор’

(4.4) цахар, ордос. [motənta:r^{ОРШИХ Т.Я.} su:]

‘Модон дээр суу’.

Увс аймгийн дөрвөд, Өвөрхангай, Баянхонгор зэрэг аймгийн халхчууд ч бас

[awtərtɑ:r] - ‘авдар дээр’, [ɔrəntɔ:r] - ‘орон дээр’ гэж ярих нь түгээмэл. Төв халхад ч ярианы хэлэнд [mʊpɪs te:r pʊ:n] - ‘МУБИС дээр бууна’. [tɛɣu:r te:r ʊ:lʃɪ:] - ‘Дэлгүүр дээр уулзъя’ гэх мэтчилэн ярьдгийг одоохондоо сургуулийн хэл зүйд буруу найруулга хэмээн шүүмжилдэг. Гэвч үүнийг арай гүнзгийрүүлэн бодож үзвэл, дурдсан монгол хэл, аялгуунуудад орших тийн ялгал шинээр үүсэн буй болж байна. Буриадын ага-хори зэрэг голлох аялгуунд ямар ч эгшигтэй үндсэнд залгах ганц [-sɔ:] байхад барга аман аялгуунд үндэстэйгээ эгшгээр зохицох [-sa:/-sə:/-sɔ:] нөхцөл байна. Төв халхад зөвхөн [te:r] байхад Өвөрхангай, Баянхонгорын халх, Увсын дөрвөд зэрэг газар [-ta:r/-te:r/-tɔ:r/-tə:r] хэмээх хувилбаруудтай байна. Энэ нь бие даасан үгээс тийн ялгалын нөхцөл болж хувирах явц аливаа хэл, аялгуу, аман аялгуунуудад харилцан адилгүй явцтай байгааг илтгэнэ.

Үүнээс гадна [-a:/-e:/-ɔ:/-ə:] нөхцөл халх зэрэг аялгуунд одоо ч орших орон заасаар байна. Жишээ нь (4.5):

(4.5) Монгол улсын хүн амын талаас илүү хувь нь нийслэл хотноо ^{орших т.я.} аж төрж байна.

[mɔŋɣɔl ʊlʃɪŋ хун ам:n tʰala:s ilu: χʏwən ni:slɛl χɔtʰnɔ: aɣʃ tʰɔrtʃ wə:n]

Өвөр монголын аялгуунуудад энгийн ярианд халхаас ч өргөн хэрэглээтэй. Жишээ нь, ордос аялгуунд [tʰɛɣʏ:n tʰɔ:ka:t jawɪ:] ‘тэргэнээ суугаад явъя’ гэх мэтээр ярьдаг.⁷ Дагуур хэлний [-a:tʰən/-ə:tʰən/-ɔ:tʰən/-e:tʰən] нөхцөл нь ч энэхүү -a/-e>[-a:/-e:/-ɔ:/-ə:] нөхцөл бүхий нийлмэл хэлбэр байж болох юм.

Харин монгол хэлэнд [-re/-ra] нөхцөл (Тодаева, 1973: 51-52), дуншаан хэлэнд [-гэ] нөхцөл бүр эртнээс орны утга заасаар иржээ (Насанбаяр, 1961: 62). Жишээ нь (4.5), (4.6):

(4.6) монгол. [pʊlɛŋɣʊ:la mɔlsere^{орших т.я.} χamtarina]
‘Хүүхдүүд мөсөн дээр гулгаж байна’.

(4.7) дуншаан. [kierɛ^{орших т.я.} wi]
‘гэртээ байна.’ гэх мэт.

Ийнхүү өнөөдрийг хүртэл “өгөх орших тийн ялгал” хэмээн нэрлэж, үндсэн хоёр утга заадаг гэж үзсээр ирсэн тийн ялгалаас орчин цагийн монгол хэлэнд орших утга салан хөгжих хандлага тодорхой харагдаж байна. Харин монгол, дуншаан хэлнүүдэд эртнээс нааш энэ тийн ялгал тусдаа байсаар иржээ.

Хэлэлцүүлэг

1. Өгөх орших тийн ялгалын нөхцөлийн гарлын тухай эрдэмтэд хэд хэдэн

⁷ “Монголын нууц товчоон”-оо “Есүхэй худ, би энэ шөнө зүүдэн зүүдлэв би. Цагаан шонхор наран, саран хоёрыг атган нисэж ирж гар дээр минь туув.” хэмээсэн байдгийг эрдэмтэн Ш.Чоймаа “Монголын нууц товчооны эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг” (УБ., 2011) бүтээлийнхээ 27-р талд тэмдэглэжээ. Энэ нь ордос аман аялгуу монгол хэлний харьцангуй эрт үеийн онцлогуудыг хадгалан үлдсэний нэг жишээ юм.


санал дэвшүүлсэн байдаг. Тухайлбал, Г.И.Рамстедт энэхүү эртний тийн ялгал нь алтай хэлний [dai] - ‘газар орон’ хэмээх үгээс үүсэлтэй бөгөөд одоо энэ үг солонгос хэлэнд байдгийг тэмдэглэсэн байна (Рамстедт, 1957: 255). М.Базаррагчаа “*tu-l, tu-si* болон *do-tu-ra* гэдгийн *tu-* язгуураас *tu-*г нөхцөл буй болжээ. Энэхүү *tu-r-*д олны утга байхгүй боловч нэг юм нөгөө этгээдэд тусаж ойртох нь олны утгын ул мөртэй юм. *da-b-qu-r, de-ge-re, do-ru, da-ra-ya, do-u-ra, du-n-da* зэрэг үгийн *da, de, do, du* зэрэг язгуураас *-da, de, d* гэсэн олон буюу хэсгийг заасан утга бүхий бүтээвэр бий болсон ба өгөх оршихын тийн ялгалын бүтээвэр салаалжээ... Энэхүү *da-* нь *da-b-qu-r* (давхар), *da-ki-* (дахь-), *do-ki-* (дохь-), *dö-kü-* (дөх-) зэрэг үгийн язгуур бөгөөд нэг юм нөгөө юманд ойртох, тусах гэсэн утгатай” хэмээн тайлбарлажээ (Базаррагчаа, 2017: 70-90). Энэ тийн ялгал нь *-da/-de* болон *dur/tur* хэмээх хоёр хэлбэрээр алтайн хэлнүүдэд түгээмэл хадгалагдаж ирснээс үндэслэн Ш.Озава *-da/-de* нь өгөхийн утгатай, *dur/tur* нь оршихын утгатай байсан хэмээн тайлсныг М.Саруул-Эрдэнэ дурдаад, уг тийн ялгалын нөхцөлийн анхдагч хэлбэр *-da/-ta* нь өгөх, *-du/-tu* нь орны утгатай байсан гээд, харин зөвхөн бичгийн хэлэнд байсан *-dur/-tur* хэлбэрийн *-г* нь чиглэх утгатай нөхцөл хэмээсэн Н.Поппегийн саналыг дэмжжээ (Саруул-Эрдэнэ, 2002: 35-36). Үүнээс гадна *-а* бол тухайн тийн ялгалын анхдагч нөхцөлийн нэг юм. Г.Д.Санжеев монгол хэлний харьяалах тийн ялгалын *и*, заах тийн ялгалын *і*, өгөх орших тийн ялгалын *а* бол тэдгээр тийн ялгалын үндсэн, анхдагч элемент бөгөөд өөр хоорондоо холбоотой хэмээн дүгнэж байсан байна (Санжеев, 1953: 158-168).

Ийнхүү тус тийн ялгал анхандаа газар оронд оршин байх ерөнхий бүхэл утгатай байсан бөгөөд өгөх, орших утгын үндсэн элемент нь *а* эгшиг болон *d* гийгүүлэгч, орших, чиглэх утгын үндсэн элемент нь *и* эгшиг болон *г* гийгүүлэгч мөн гэдэгт эрдэмтэд үндсэндээ санал нэгдэж байна. Эндээс дүгнэвэл, тус тийн ялгалын хамгийн эртний хэлбэр нь орших утгат, орчин цагийн монгол хэлэнд *а-* хэмээх дутмаг үйл үгийн язгуураар үлдсэн *-а/-е* байсан бөгөөд түүнийг залган гарч ирсэн *-da/-de* болон *-dur, -du* нөхцөлүүд утгын хувьд адилхан байжээ. Харин *-dur, -du* хоёрын аль нь эхний хэлбэр вэ гэдэг талаар бас харилцан адилгүй санал бий. Тухайлбал, Н.Н.Поппе *-du* дагавар дээр чиглэх утгат *-г-ийг* залгаж бүтсэн гэсэн бол Г.Д.Санжеев *-dur-*ын *г* гийгүүлэгч нь гээгдсэн хэмээжээ. Хожим нь Өвөр Монголын эрдэмтэн Хасбаатар дурсгалт бичгүүдээс шүүж үзсэний дүнд эхлээд бүхэл утгат *-dur* нь байсан гэсэн дүгнэлтэд хүрсэн байна. Энэ нь түүний “Монгол хэлний тийн ялгал нь тооны тал дээр цөөнөөс олон тийш, утгын тал дээр нэн нарийн нягт оновчтой болох зүгт хөгжиж байна” (Хасбаатар, 1982: 189) гэсэн дүгнэлттэй тохирно. Эрдэмтэн Хасбаатар бас нэг чухал зүйлийг ажигласан нь: “Биеийн төлөөний нэр үгийн тийн ялгалын хувилал нь монгол хэлэнд (энд буриад, ойрадыг оруулсан. Г.Б.) харьяалах, төрөл хэлнүүдэд харьяалах-заахын тийн ялгалыг гаргавал бусад нь цөм өгөх оршихын тийн ялгалын суурин дээр хувилж байна (Хасбаатар, 1982: 194-205) гээд, дараах жишээгээр нотолжээ. Үүнд: Монгол. [natət, nati:~namæ:k~mani:, nata:s, nata:r~nama:r, natlæ:~namlæ:,

natt^hæ:~nam^hæ:]. Монгол. [nta:, nta:sa, nta:la, nta:ti:, nta:dzə]. Даргуур. [namt~na:t, nama:r, nama:s, nam^hi:]. Бао-ань. [mənta, mənса]. Зүүн ёгур. [nanta, nantasa, nantaka:r, nantala, nantapi:t]. Дуншаан. [namatə~matə, namasə~masə, namalə~malə]. Цааш нь тэрээр биеийн төлөөний үгс бол байнга хэрэглэдэг, хэлний хамгийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд үгийн сангийн бусад бүрэлдэхүүн хэсгийг бодвол түүний хувьсал хөгжил нь харьцангуй алгуур удаан, хэвшмэл чанар нь илүү байдгийг тэмдэглэжээ. Мөн тийн ялгалуудын утгын сүлжилдээг ажигласан ч энэхүү нөхцөл нь нэрлэх, харьяалах-заахаас бусад олон зүйл тийн ялгалын утгыг илтгэж байсныг харж болохыг дурдаад, дараах дүгнэлтэд хүрсэн байна: Өгөх орших тийн ялгал нь монгол хэлний анхны тийн ялгалын нэг (үндсэндээ харьяалах-заах тийн ялгалын дараах), тэр дундаа -da нөхцөл нь илүү эртнийх, тухайлбал бүр алтай хэлний үеийнх болохыг харуулна гээд ‘dai’ (газар) хэмээх үгээс гаралтай хэмээсэн эрдэмтэн Г.И.Рамстедтийн саналыг дэмжсэн байна (Хасбаатар, 1982: 194-205).

Ийнхүү, монгол хэлний анхдагч, үндсэн тийн ялгалын нэг өгөх орших тийн ялгал нь -a, -da, -dur нөхцөлтэй байснаа дундад зууны үе болж ирэхэд бичгийн хэлэнд t (-a/-e) -ээс гадна r гийгүүлэгчтэй (-dur/-dür), (-tur/-tür), r гийгүүлэгчгүй (-du/-dü), (-tu/-tü) хэмээх үндсэн хоёр хувилбартай болж, -da/-ta хэлбэр нь байхгүй болжээ. Харин монгол хэлнүүдийн аман ярианд эдгээр хэлбэрийн аль нь ч хаягдаж алга болсонгүй, янз бүрээр уламжлан хөгжсөөр орчин цагийн зүүн ёгур, бао-ань хэлэнд [-ta/-te], дуншаан хэл, мөн монгол хэлний хүзү аялгуунд [-tə], халимагийн ойрад хэлэнд [-ti/-te], [-tʰi/-tʰe], буриад хэл, аялгуунд [-da/-de/-dɔ], [-tʰa/-tʰe/-tʰɔ] хэмээн a/e>[a/e/ɔ/i], [ə] эгшгийн хамт уламжилсан байна. Бичгийн хэлэнд үлдсэн u/ü эгшигт хэлбэр орчин цагт зөвхөн могол хэл, монгол хэлний минхэ аялгуунд байх бөгөөд r гийгүүлэгчгүй. Харин монгол хэлний халх, өвөр, ойрад аялгуу, дагуур хэлэнд эгшиг нь гээгдэж [-t/-tʰ] болсон. Монгол, дуншаан хэлэнд өгөх тийн ялгал нь орших тийн ялгалаас тусдаа хөгжиж ирсэн нь энэхүү тийн ялгалын үүсэл гарал, хувьсал хөгжлийн замыг батлан харуулах нэгэн чухал баримт болно. Нөгөө нэг (-a/-e) нөхцөл нь халх, өвөр аялгуунд [-a:/-e:/-ɔ:/-ə:] хэмээн уламжилж ирэхдээ залгасан үндэстэйгээ эгшгээр зохицох хувилбаруудтай болсон, харин зүүн ёгур, дагуур хэлэнд [-ə/ə] эгшгээр үлдсэн. Үүнийг загварчлан үзүүлье.

*a-, *dai- > ЭМХ. -a, -da, -dur > ДМХ.Мо. -a, -du/-dü/-tu/-tü, -dur/-dür/-tur/-tür >




2. Гарах тийн ялгал нь өгөх оршихын тийн ялгалын суурин дээр бий болсныг удиртгалд товч дурдсан. Мөн Өвөр Монголын эрдэмтэн Хасбаатар гийгүүлэгч авианы бүтэх арга болоод төрөл хэлнүүд дэх хувилбараас үүдэн сонирхолтой санал дэвшүүлжээ. Тэрээр, дагуур хэлэнд гарах тийн ялгалын нөхцөлийн [-a:t/-ə:t/-ɔ:t/-e:t] хэмээх хувилбар байдаг нь [-a:s/-ə:s/-ɔ:s/-e:s]-ийн хувилбар уу? эсвэл үйлдэх тийн ялгалын нөхцөл үү?, [s]-ээс өөр гийгүүлэгчтэй хувилбар бусад хэл, аялгуунд байна уу? гэдгийг эрэлхийлэн судалсан байна. Гэтэл ойрадын дөрвөд аман аялгуунд уг тийн ялгалын [-a:t^h] (atɔ:na:t^h, nata:t^h) хувилбар байдаг аж. Дагуур хэлний [r] гийгүүлэгч бусад монгол хэлний [t/d] гийгүүлэгчтэй тохирох тохиолдол бий. Жишээ нь: [k^hək^hur] - 'хүүхэд', [ujir] - 'охид' гэх мэт. Үүнээс гадна, өнөөгийн алтай язгуурын зарим хэлэнд гарахын тийн ялгал нь [ta/t^ha] бүхий хэлбэрээр байдаг ажээ. Үүнд: турк хэлэнд [-tan/-t^han], якут хэлэнд [-ta], манж хэлэнд [-teri/-t^heri], уйгур хэлэнд [-tin/-t^hin], шивэй хэлэнд [-teri], орчоон хэлэнд [-tuk/-t^huk] нөхцөл байдаг аж. Г.И.Рамстедт турк хэлний [-tan] нөхцөлийг -da+jan>[-tan] хэмээх хоёр элементээс бүрэлдсэн гэж үзсэн. Энэ ёсоор үзвэл алтай хэлнээс салбарласан эдгээр хэлний гарах тийн ялгалын нөхцөлүүд бүгд тухай тухайн хэлнийхээ өгөх орших тийн ялгалын суурин дээр бүтэж бүрэлдсэн, гэхдээ якут зэрэг хэлэнд уг хоёр тийн ялгал салбарласангүй, харин дурдсан бусад хэлэнд өгөх орших тийн ялгал дээр өөр нэг элемент нэмэгдэж гарах тийн ялгалын нөхцөл бүрэлдсэнийг олж үзэж болно. Тэгэхлээр, гарах тийн ялгалын анхдагч нөхцөл -ца нь -da/-ta>-ца(-tʃa)>-sa хэмээн гийгүүлэгч сулран хувьссанаас бий болжээ. Өөрөөр хэлбэл, өгөх орших, гарахын тийн ялгал эхлээд гарал нэгтэй байгаад, хөгжлийн явцад хоёр салахдаа -da/-ta хэвээр үлдсэн нь өгөх орших утга, -da/-ta>-ца(-tʃa)>-sa хэмээн суларч хувьссан нь гарах утга илтгэж байжээ. Гэвч энэ хоёр хэлбэр шууд л тодорхой заагтайгаар салж хоёр тийн ялгал болчихсонгүй хэсэг хугацаанд хутгалдан холилдож явсаар, саях -ца хэлбэр нь монгол хэлний эрт болон дунд үед дахин өгөх оршихын -а болон -da/-ta-тай нийлж -аца, -daца/-taца хэмээх шинэ хэлбэрийг үүсгэсний дараа сая хоёр өөр тийн ялгалын зааг ялгаа тодрон хөгжсөн хэмээх дүгнэлтийг хийсэн байна (Хасбаатар, 1982: 210-214). Харин буриад, монгол, зүүн ёгур, бао-ань, дуншаан хэлнүүдэд анхдагч -ца(-tʃa)>-sa хэлбэр нь уламжлан үлджээ.

XVII зуун болж ирэхэд -ца/-це>-аца/-еце, -daца/-deце~taца/-teце хэмээх хоёр хэлбэр бичгийн хэлэнд байсан бөгөөд -ца/-це-ийн аман ярианы хувилбар нь -sa/-se, харин -аца/-еце-ийн аман ярианы хэлбэр нь -asa/-ese байсныг Өвөр Монголын эрдэмтэд бичгийн дурсгалуудаас тогтоосон байдаг (Зоригт, Элсэнцэцэг, 2001: 82-103). Үүнээс, эхний а эгшиг нь тод хэлэгдэж байснаас яваандаа урт эгшиг болж, эцсийн эгшиг гээгдсэн хэлбэр нь монгол, ойрад, буриад хэлнүүдэд хэвшин тогтсон байна.

Ийнхүү дээрх олон эрдэмтний санал дүгнэлт, ажиглалт судалгаа болон хэлний баримтаас орших ба гарах тийн ялгалын холбоо харьцаа, хамжих

гийгүүлэгчийн сулрах хувьсал, түүнчлэн эгшиг авианы уртсах, сугаран гээгдэх хувьсал тодорхой болж байна. Үүнд: орчин цагийн монгол хэлний үндсэн тийн ялгалуудын нэг гарах тийн ялгалын нөхцөл нь анх *da/ta>ča* хэмээх бүтэцтэй байснаа эртний болон дунд үеийн монгол хэлэнд *a*, *da/ta+ča* хэмээх нийлэмжээс үүссэн *-ača/-eče*, *-dača/-deče~tača/-teče* хэлбэрүүдтэй болсон бол сонгодог монгол монгол бичгийн хэлэнд (*-ača/-eče*) хэмээх хэлбэрээр дүрэмжиж, нөгөө нь хэрэглээнээс гарчээ. Түүнээс хойш орчин цагийн монгол хэлнүүдэд авианы хувьслын гурван өөр шугамаар хөгжсөн байна. Үүнд:

**da/ta>ča>-a*, *-da/-ta+ča>ЭМХ.-ača*, *-dača/-tača>ДМХ.Мо.-ača/-eče >*



3. Чиглэх тийн ялгалын гарлын хувьд: ДМХ. *ekin inu nigente delde'ed* - 'толгой руу нь нэг удаа цохиод' (Чоймаа, 2011: 40) > ОЦМХ. өвөр. [tʰɔlɛktən ʃʰɔχɔ:t] > халх. [tʰɔlɛktɔ:n tʰɔχɔ:t] гэх мэтээр нөхцөлгүй тийн ялгалаас газар оронд орших тийн ялгал, түүнээс газар орон руу чиглэх тийн ялгал хэмээх дарааллаар бий болсон байна. Харин бүтээврийн гарлын хувьд: Алтай язгуурын түрэг, манж хэлнүүдэд зүг чигийн утгат -г нөхцөл байдаг байна (Рамстедт, 1952: 35-40). Ойрад хэл, аялгуу болон зүүн ёгур хэлэнд энэхүү эртний -г бүтээврээс [-u:r/-y:r] нөхцөл, дуншаан хэлэнд [-ron/-lon] нөхцөл бий болжээ. Харин орчин цагт мөн утгат иигүй хэмээх үгээс монгол хэлний халх, цахар, мянгад зэрэг аялгуунд [-ro:/-ru:/-ry:/-lo:/-lu:/-ly:] нөхцөл үүссэн байх бөгөөд энэхүү г гийгүүлэгч, и эгшиг хоёр олонх монгол хэл, аялгуун дахь зүг чигийн утгат үг болон бүтээвэрт хадгалагдсаар иржээ. *ögede* хэмээх үгээс халх аялгуунд [-a:t/-e:t/-ɔ:t/-ø:t] нөхцөл, торгууд, алшаа эзнээ аялгуунд [-a:t/-æ:t] нөхцөл үүссэн. Ийнхүү ЭГЭ нийлцээс урт эгшиг үүсэн хөгжиж, бие даасан үгийн өргөлт нь гээгдсэнээр нөхцөл бүтээвэр болсон, улмаар өмнөх үндэстэйгээ эгшиг ба гийгүүлэгчийн талаар зохицох хувилбаруудтай болсон бол зүүн ёгур хэлэнд [rite] (ойр орчин) хэмээх үгээс [-ri:t/-i:t] хэмээх нөхцөл үүссэн байна. Эдгээр үг, бүтээвэрт бас өгүүлж буй эртний тийн ялгалын *d>[t]* гийгүүлэгч хадгалагдсаар иржээ. Харин өвөр монголын үзэмчин салбар аман аялгуунд *jüg* хэмээх үгээс [-ʃʊ:/-ʃu:] хэмээх нөхцөл шинээр үүсэж байна. Загварчлан харуулбал:

*-r —————> ОЦМ. ойр., зүүн ёг. [-u:r/-y:r], дунш. [-ron/-lon]
 ДМ. *uruγu>uru'u* —————> ОЦМ. халх. [-ro:/-ru:], [-lo/-lu:]

ДМ. *ögede* > *ö'ede* → ОЦМ. халх. [-a:t/-e:t/-ɔ:t/-ø:t], тор., алш. [-a:t/-æ:t]
 ДМ. *jüg* → ОЦМ. үзм. [-ʃʊ:/-ʃu:], мнгр. [-dzə]
 ДМ. *bide* → ОЦМ. зүүн ёг. [-pi:t/-i:t]

4. Орших тийн ялгал нь монгол, дуншаан хэлнүүдэд г гийгүүлэгчтэйгээр эртнээс уламжилж ирсэн бол дагуур болон буриад, ойрад, монгол хэлний аялгуунуудад орчин цагт бие даасан үгээс шинээр үүсэн бүрэлдсэн байна. Нөгөө -a/-e нөхцөл нь халх, өвөр аялгуунд [-a:/-e:/-ə:/-ɔ:/-ø:] хувилбаруудаар, зүүн ёгур, дагуур хэлэнд [-ə/ə] эгшгээр одоо ч байна. Үүнд:


*r > ОЦМХ. мнгр. [-ra], дунш. [-rə]
 ДМХ. *dotur-a* > ОЦМХ. цах., баар., харч. [-tʰər]
 ДМХ. *čoyu* > ОЦМХ. ага-хори бур. [-sɔ:], барга бур. [-sa:/sə:/-sɔ:]
 ДМХ. *deger-e* > ОЦМХ. халх. [-te:r], халх, орд., дөр. [-ta:r/-te:r/-tə:r/-tø:r]
 *a > ОЦМХ. зүүн ёг. [-a/-e], халх, өв., ойр. [-a:/-e:/-ə:/-ɔ:/-ø:],
 даг. [-ə], [-a:tʰən/-ə:tʰən/-ɔ:tʰən/-e:tʰən]

Утгын хувьд ч дээрх тийн ялгалууд нэлээд сүлжилдсэн байдалтай байдгийг эрдэмтэд янз бүрээр тайлбарласан байдаг. Тухайлбал, зүүн ёгур хэлний тухай тусгайлан судалсан Өвөр Монголын эрдэмтэн Жалсан ийнхүү өгөх оршихын тийн ялгалын нөхцөлөөр бусад тийн ялгалын утгыг илэрхийлдэг явдал нь ойр зэргэлдээ аж төрдөг төвөд хэлний нөлөө хэмээн үзжээ (Жалсан, 1982: 96-116). Харин бид тэрхүү утгын сүлжилдээг энэ мэт, тийн ялгалуудын нэг нь нөгөөгөөс салбарлан хөгжсөнтэй холбоотой гэж үзэж байна.

Ийнхүү монгол хэлнээ маш эрт үүсэн бий болсон орны ерөнхий утгат тийн ялгал монгол хэлний хөгжлийн эрт болон дундад үе, улмаар орчин цаг хүртэл монгол төрөл хэл, аялгуунуудад янз бүрийн явцтайгаар цэгцрэн хөгжиж байна.

Дүгнэлт

Энэ бүх тайлбар, судалгаа, орчин цагийн монгол хэл, аялгуунууд дахь нөхцөлүүдийн хэлбэр, утгын хувьсал хөгжлийн логикийг бодож үзвэл эдгээр тийн ялгалын үүсэл, бүрэлдлийн талаар дараах дүгнэлт урган гарч байна: Эхлээд орших болон орны утга бүхий үгээс орших ерөнхий утгат бүтээвэр бий болжээ. Энэхүү, монгол хэлний хөгжлийн маш эрт үед үүссэн тийн ялгал нь өнөөг хүртэл өгөх орших тийн ялгал байсаар ирсэн бол барагцаагаар эртний монгол хэлний үед хөдлөх утга салбарлан гарсан нь гарах тийн ялгал болжээ. Дараагийн шатанд, дунд үеийн монгол хэлнээс орчин цагийн монгол хэл хүртэлх хөгжлийн явцад газар орон руу чиглэн хөдлөх утгат тийн ялгал үүсэн бүрэлджээ. Харин орчин цагийн монгол хэл, аялгуунуудад оршин байх орныг заах нөхцөлүүд бие даасан үгээс шинээр үүсэн бүрэлдэж, өгөх ба орших тийн ялгал салаалан хөгжих хандлага нэгэнт бий болсон байна. Үүнийг загварчлан үзүүлье.



Abstract:

Scientists have found out after doing the research that in Mongolian language, Locative-dative case is one of the initial suffixes that have been formed following the genitive-accusative suffixes. Moreover, with the manuscript studies around, it has been proven that ablative suffixes were initiated in the frame of going further away from a place that was branched from locative-dative suffixes. In some of Mongolian sub-language and dialects, directive suffixes were created from one of the elements in the case grammar morpheme, and followed with next generations as custom throughout the time. Recently, locative-dative suffix has been developed differently in Mongolian language and dialects which resulted into new developing approach that locative-dative suffixes could indicate two different meanings - Locative and Dative. Furthermore, it could derive as in the shape of morpheme, which will make its definition clearer. So, the patterns of alive language development will be continuing in Mongolic languages.

Ном зүй

Базаррагчаа, М. (2017) “Монгол хэлний нэрийн тийн ялгалын нөхцөлийн гарлын тухайд” (1997). ‘Монгол хэлний бүтээвэр судлал’ эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган. Улаанбаатар, 70-90. [Bazarragchaa, M. About the origin of the Noun’s cases in the Mongolian language]. ‘Mongol khelnii бүтеевэр

- sudlal' collection of academic articles, 2017, 70-90.
- Барайшир, Ш.** (2012) “Монгол хэлний гарахын тийн ялгалын тухай асуудалд” (1961). ‘Монгол хэл шинжлэлд дуудах нэртэй, дугуйлах бууцтай эрдэмтэн’ эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган. Улаанбаатар, 144-161. [Baraishir, Sh. About the origin of the Ablative case in the Mongolian language], ‘Mongol khel shinjleld duudakh nertei, duguilakh buutstai erdemten’ collection of academic articles. 2012, 144-161.
- Бертагаев, Т.А.** (1964) “К генезису некоторых падежей в монгольских языках”. Краткие сообщения Института народов Азии АН СССР. Москва: Вып 83. [Bertagaev, T.A. About the origin of the some cases in the Mongolian language]. Brief communications from the Institute of Asian Peoples of the USSR Academy of Sciences. Vol. 83
- Жалсан.** (1982) “Jegün Yugur kelen-ü teyin ilyal ba tölügen-ü ner-e-yin ončaliy”. Öbür Mongyol-un Yeke Surayuli-yin Mongyol kele bičig sudulqu yačar-un sudulun suruyči-yin tegüsülte-yin ögülel. Хөххот, 1982. 10. 96-116. [Jalsan. Features of the Cases and Pronouns of Eastern Yugur language]. Collection of academic articles of University Inner Mongolia, Institute of Mongolian Study. 1982. 10. 96-116.
- Лувсанвандан, Ш.** (1965) “Орчин цагийн монгол хэлний шууд ба шууд биш тийн ялгал”. МУИС-ийн багш нарын эрдэм шинжилгээний бичиг. Улаанбаатар, VIII боть 2(16), 25-30. [Luvsanvandan, Sh. Direct and indirect cases of Modern Mongolian Language]. Journal of Mongolian National University. Vol. VIII, 2(16), 25-30.
- Лувсандэндэв, А.** (2017) “Наймдугаар үндсэн тийн ялгал” (1954). ‘Монгол үндэстний утга зохиолын хэл бүрэлдэн тогтсон нь’ эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэл. Улаанбаатар, 136-140. [Luvsandendev, A. Eighth basic case]. ‘Formation of Mongolian literary language’ collection of academic articles. 2017. 136-140.
- Лувсанжав, Чой.** (1972) “Монгол хэлний тийн ялгалын тухай”. МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. Улаанбаатар, №41. [Luvsanjav, Choi. About of the cases of Mongolian language]. Journal of Mongolian National University. Vol. 41.
- Нансалмаа, Н. Долгор, С.** (2014), Танихуйн хэл шинжлэл. Улаанбаатар: МУИС пресс. [Nansalmaа, N and Dolgor, S. Tanikhuin khel shinjlel. [Cognitive Language]. Ulaanbaatar. MUIS press. 2014]
- Насанбаяр.** (1961) “Дуншаан хэлний товч тэмдэглэл”. Монголын судлалын зарим асуудал. ШУАХ. Улаанбаатар, 62-75. [Nasanbayar. A brief note about of Dongxian language]. Some problems of Mongolian study. 1961. 62-75.
- Рамстедт Г.И.** (1957) Введение в алтайское языкознание, Москва. [Ramstedt, G.J. Introduction Altaic Linguistic. Moscow]
- Санжеев Г.Д.** (1953) Сравнительная грамматика монгольских языков I. Москва.

- [Sanjeyew, G.D. Comparative grammar of Mongolic languages]
- Саруул-Эрдэнэ, М.** (2002). Монгол хэлний нөхцөл бүтээврийн үгзүйн түүхэн хувьсал. Улаанбаатар. [Saruul-Erdene, M. Монгол хэлний нөхцөл бүтээврийн үгзүйн түүхэн хувьсал. [The Historical evolution of Morphology of Mongolian Language]. Ulaanbaatar, 2002]
- Цэрэнсодном, Д. Наранцэцэг, Д.** (2021) “Молом Равжамба Данзандагвын ‘Богд Чойжи-Одсэр бээр зохиосон зүрхний толтын тайлбар үсгийн эндүүрлийн харанхуйг арилгагч Огторгуйн маани’ хэмээх дурсгал. Монгол хэл шинжлэлийн үнэт дурсгалууд. Улаанбаатар. 56-95. [Tserensodnom, D and Narantsetseg, D. Molom Ravjamba Danzandagva’s ‘Ogtorguin maani - the Explanation of ‘Zürkhen tolt’’. Valuable monuments of Mongolian linguistics. 2021. 56-95.
- Чоймаа, Ш.** (2011) Монголын нууц товчооны эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг. Улаанбаатар. [Choimaa, Sh. Mongolin nuuts tovchooni ertnii üg khellegiin tügeemel tailbartai shine khörvүүлэг. [A new translation with a popular explanation of the ancient words of the Mongolian Secret History]. Ulaanbaatar. 2011]
- Шагдарсүрэн, Ш.** (2017) “Монгол хэлний тийн ялгалын нэр томъёо, түүний гарлын асуудалд” (1998), ‘Монгол хэл шинжлэл Алтай судлал’ эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган. Улаанбаатар, 45-55. [Shagdarsuren, Ts. Mongolian case’s terminology and its derivation]. ‘Mongolian linguistic and Altai studies’ collection of academic articles. 2017. 45-55.
- Čengeltei, Čoyijungjab.** (2005) Odu uy-e-yin mongyol kele. Kökeqota: Öbür Mongyol-un Yeke Suryayuli-yin Mongyol sudulul-un dededü suryayuli-yin Mongyol kele bičig sudulqu yaĵar. [Chengeltei and Choiĵinjaw. Odoо üyiin mongol khel. [Modern Mongolian Language]. Hohhot: University of Inner Mongolia, Institute of Mongolian Study. 2005]
- Go Joriytu, Elesünčėčeg.** (2001) Mongyol kelen-ü teyin ilyal sudulul. Kökeqota: Öbür Mongyol-un Suryan Kümüjil-ün Keblel-ün qoriy-a. [Zoright and Elsentsetseg. Mongol kelnii tiin yalgal sudlal. [Study about of Case of Mongolian Language]. Hohhot: Press of Educational of Inner Mongolia. 2001]
- Garudi, Elesüčėčeg, Erdeničuyla, Naranyow-a, Batugerel, Galsang, Delger, Delgerm-a.** (2007) Orčin čay-un mongyol kele. Kökeqota: Öbür Mongyol-un Suryan Kümüjil-ün Keblel-ün oriy-a. [Garudi nar. Orchin tsagiin mongol khel. [Modern Mongolian Language]. Hohhot: Press of Educational of Inner Mongolia. 2007]
- Manliyan.** (2012) Mongyol kele ayalun-u kelberi sudulul. Liyooning: Keblel-ün qoriy-a. [Manliyan. Mongol kele ayalguuni kelber sudlal. [Morphology of Mongolian Language and Dialects]. Liyoning Press. 2012]
- Poppe, N.N.** (1955) Introduction to Mongolian Comparative Studies, Helsinki: MS-

FOu. 110

- Pürbū. Ts.** (2019) “Mongyol kele sinjilel-ün durasqaltu bičig - ‘Jirüken-ü tolta-yin tailburi Oγtaryui-yin mani’-yi ungsiγsan temdeglel”. Erdem sinjilegen-ü бүтүгел-үн тегүбүри. Kökeqota, 2019. 410-430. [Pürev. A note about of ‘Ogtorguin maani’ which the Explanation of ‘Zürkhen tolt’-Mongolian Linguistic Monument]. Collection of academic articles. 2019. 410-430.
- Qasbayatur.** (1982) “Mongyol törül kelen-ü teyin ilγal-un tuqai”. Öbür Mongyol-un Yeke Surγayuli-yin Mongyol kele bičig sudulqu γačar-un sudulun suruγči-yin tegüsülte-yin ögülel. Xөxxor, 1982. 10. 194-205. [Khasbaatar. About of the Cases of Mongolic languages]. Collection of academic articles of University Inner Mongolia, Institute of Mongolian Study. 1982. 10. 194-205.
- Rachewiltz, I.D.** (1972). Index to the Secret History of the Mongols. New York: Indiana University Publications Uralic and Altaic series, Volume 121.
- Ramstedt, G.J.** (1902) Über die conjugation des Khalkha-mongolischen, Helsingfors: MSEOu 21, XV.
- Ramstedt, G.J.** (1952) Einfuhrunf in die altaische Sprachwissenschaft, II. Formenlehre. Helsinki.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.